



ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

(Хараат бус аудит, аутсорсинг)

2022 оны 03-р сарын 15-ны өдөр

№ 22/120

Улаанбаатар хот

"Хоринхоёрдугаар бааз" ХК-ийн Удирдлага танаа

ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын дүгнэлт:

Бид Аудитын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу "Хоринхоёрдугаар бааз" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон Санхүү байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу материаллаг алдаа, зөрчилгүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитын ажлаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, Монгол улсын аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу бид үйлчлүүлэгч компаниас хараат бус бөгөөд ёс зүйн шаардлагаа бүрэн биелүүлсэн.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага:

Санхүүгийн тайлангуудыг СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулж, тогтмол мөрдөж ажиллах нь компанийн удирдлагын үүрэг болно.

Мөн санхүүгийн тайлангуудыг заль мэх, алдаанаас үүдэлтэй буруу илэрхийллээс ангид бэлтгэж шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг бий болгон ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь зарчмыг хангаж ажиллах нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

СТА-2022-120-ААН

ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Хуудас: 1/1

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага:

Бидний үүрэг бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад алдаа эсвэл залилангийн улмаас материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд дүгнэлт өгөх явдал юм. АОУС нь санхүүгийн тайлангуудад материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаарх зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Иймд тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловсруулсан горимын дагуу шалгалт хийж, хангалттай, тохиромжтой баримт нотолгоо цуглуулах үүрэгтэй.

Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийг тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа, залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдэлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллууд, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Хэрэглээний хязгаарлалт:

Энэхүү тайлан нь Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчидэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.



Д.ЭНХБААТАР
/Аудитор, МНБ/